



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 24 өдөр

Дугаар A/288

Улаанбаатар хот


Г Зам, тээврийн салбарт жендэрийн талаар
баримтлах бодлого батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зам, тээврийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого”-ыг нэгдүгээр, бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Жендэрийн талаар баримтлах салбарын бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, жил бүр Жендэрийн үндэсний хороонд тайлagnaыг Төрийн нарийн бичгийн дарга бөгөөд Жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийн дарга /С.Батболд/-д үүрэг болгосугай.





Зам, Тээврийн хөгжлийн сайдын 2020 оны дугаар сарын
-ны өдрийн дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРТ ЖЕНДЭРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ

ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГДАНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

10-266063 5019487

Зорилго: Зам, тээврийн салбарын бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгэнд жендэрийн агуултыг тусгах, жендэрийн талаарх мэдлэг ойлголт, хандлагыг өөрчлөх, салбарын үр шимийг эрэгтэй эмэгтэй хүмүүст тэгш хүртээх, гэр бүлд зэлтэй хөдөлмөрийн харилцааны орчин нөхцөлийг бурдуулэх, бүх хүрээнд хамтын ажиллагаа түншлэлийг хөгжүүлэх замаар жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд энэхүү бодлогын зорилго оршино.					
№	Үйл ажиллагааны чиглэл	I Уе шаг: 2021-2023		II Уе шаг: 2024-2026	
		Арга хэмжээ	Шалгур Узүүлэлт	Арга хэмжээ	Шалгур Узүүлэлт
Зорилт.1	Зам, тээврийн салбарын хэмжээнд жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг, ойлголтыг бүх түвшинд нэмэгдүүлж, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хэрэгжүүлэх нөхцөл бурдуулэх Хүрэх үр дүн: Зам, тээврийн салбарт бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээг жендэрийн мэдрэмжтэй хийх чадавхи болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хэрэгжүүлэх нөхцөл бурдуулэх				
1.1.	Зам, тээврийн салбарын хэмжээнд жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг, ойлголтыг бүх түвшинд нэмэгдүүлж, Жендэрийн эрх тэгш байдлын талаарх мэдлэг, ойлголтыг бүх түвшинд намэгдүүлэх;	1.Жендэрийн эрх тэгш байдлын талаарх мэдлэг олгох сургалт зохион байгуулах	Зохион байгуулсан сургалтын тоо	1.Зам, тээврийн салбарын Мэргэжилтийн бүрдсэн жендэрийн сургач багш нарын баг бурдуулэх	Сургагч багшийн тоо, хүйсээр
1.2.		2.Ажлын байранд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар гарын авлага боловсруулах	Гарын авлага	2.Авто зам, авто тээвэр, темөр замын мэргашсан зэрэг горилогч, инженерүүдэд олгох сургалтын хөтөлбөр	Жендэрийн мэдрэмжтэй сургалтын хөтөлбөр

			мэдрэмжтэй бүтцийн агуултыг тусгах	дэд талаарх
1.3.	3.Зам, салбарын жендэрийн сурталчах зохион байгуулах;	Зохион байгуулсан сургалтын тоо	3.Зам, тээврийн салбарын жендэрт зохистой хөдөлмөрийн нөхцөл сургалт бүрдүүлэх зохион байгуулах;	Зохион байгуулсан сургалтын тоо
1.4.	4.Удирдах ажилтнуудад зориулсан жендэрийн цахим сургалтын хөтөлберийг салбарын Үйл ажиллагаанд НИЙЦШУЛЭН нэвтрүүлэх	Цахим сургалт нэвтрүүлсэн байх	4.Салбарын хүчин нөөц бэлтгэж буй тэр, хувийн хэвшлийн боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт заавал судлах хичээлийн агуулгад нь жендэрийн үнэлгээ, шинжилгээ, жендэрийн мэдрэмжтэй дэд бүтцийн талаар тусгахад хамтран ажиллах	Хамтран ажилласан байгууллагын тоо, жендэрийн асуудал тусгасан хөтөлбөрийн тоо
1.5.	5.Шинээр ажилд орсон ажилтанд зориулсан сургалтын хөтөлберийг жандэр, байгууллагын соёл, хүний эрхийн асуудлыг боловсруулж ашиглах	Боловсруулсан сургалтын хөтөлбөр	Шинээр ажилд орсон ажилтанд зориулсан сургалтын хөтөлбөр, Үйл ажиллагаанд үнэлгээ хийх шалтуур үзүүлэлтийг тогтоох	Үнэлгээний Тайлан
1.6.	6.Зам, салбарын байгууллагын цахим хуудсанд жендэрийн эрх тэш байдлыг хангаж буй талаарх мэдээллийг байгуулах	Цахим хуудсанд мэдээлэл байгуулсан байгууллагын тоо		

7.3ам, салбарын жендэрийн шинжилгээ зүйг нэвтрүүлэх	тээврийн хэмжээнд Дүн арга зүйг боловсруулсан	Жендэрийн Дүн шинжилгээ хийх арга зүйг боловсруулсан	
8.Харьяа байгууллагуудын ажлын байр хуульд заасан нөхцөл шадрлага хангаж буй эсэхийг судлах	Судалгаа хийгдсэн байх		
1.7. Жендэрийн асуудлаар мэргэшсэн салбарын сургач багш нарыг бэлтгэх сургалт зохион байгуулах	Салбарын хэмжээнд жендэрийн сургач багш бэлтгэх сургалтын хөтөлбөр боловсруулах	Боловсруулсан сургалтын хөтөлбөр	Салбарын хэмжээнд жендэрийн мэдрэмжтэй сургалт зохион байгуулах багшиар бэлтгэх
1.8. Зам, тээврийн салбарын хэмжээнд баримтлах жендэрийн бодлогыг танилцуулах мэдээлэл сургалт, сургалчлааны ажил зохион байгуулах	Салбарын хэмжээнд жендэрийн бодлого, хэрэгжилтийг асудлыг салбарын бүх түвшиний шийдвэр гаргагч, бодлого боловсруулагчдад танилцуулах	Зохион байгуулсан сургалт болон оролцогчдын тоо хүйсээр	Сургач багш нарын тоо
1.9.	Салбарын хэмжээнд баримтлах жендэрийн бодлогыг сургалчлах гарын авлага боловсруулах	Гарын авлага	

1.10.		Салбарын байгууллага бүрт жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж, тайлагнах удирдамж боловсруулан хүргүүлэх	Байгууллагын түвшинд ашиглах удирдамж	
1.11.	Жендэрийн хэвшимэл ойлголт, тэгш байдлыг хангах, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх сургалтад жендээр, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтийн хамруулах	Жэндэрийн хэвшимэл ойлголт, тэги байдлыг хангах, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх харуулсан мэргэжилтийн хамруулах	Боловсруулсан сургалтын хөтөлбөр	Салбарын хүний нөөцийн хөтөлбөр жендэрийн мэдрэмжтэй эсэхэд үнэлгээ хийх
1.12.	Салбарын хэмжээнд болон байгууллагын түвшинд жендэрийн хэвшимэл ойлголт, тэгш байдлыг хангах, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх сургалтгыг зохион байгуулах	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо хүйсээр		
1.13.	Салбарын хэмжээнд Ёс зүйн болон сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчдын жендэрийн байдалд дун шинжилгээ хийж тайлагнах	Хүйсийн судалгаа хийгдсэн байх		

Зорилт 2. Салбарын хэмжээнд хүйсээр ангилсан статистик мэдээллийг бүрдүүлэх, ашиглах чадавхыг дээшшуулэх, жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан аливаа хүчирхийллээс ангид ажлын орчинг бий болгох

Хүрэх ҮР ДҮН: Хүйсээр ангилсан мэдээллийн нэгдсэн санг хүний нөөцийн бодлого төлөвлөгөөнд ашиглаж, эзэтэй, эмэгтэй ажилчдад тэгш боломж бүрдүүлэхүйц байгууллагын соёл, ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх механизм төлөвшиж, ажил-ар гарийн амьдралын тэнцвэрт байдлыг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй ажлын орчин бүрдэнэ.

2.1.	Салбарын хэмжээнд хүйсээр ангилсан мэдээллийн нэгдсэн сан бурдучуулж, хүний нөөцийн бодлого төлөвлөлтөнд ашиглаж	Төрийн захирагааны төв байгууллагаас хүйсээр ангилсан мэдээллийн сан бурдучуулж	Салбарын албан хаагчдын хүйсээр ангилсан мэдээллийн сан дахь мэдээллийн тоо	Салбарын ажилтан, албан хаагчдын хүйсээр ангилсан мэдээллийг тогтолцоог салбарын хэмжээнд бий болго	Салбарын ажилтан, албан хаагчдын хүйсээр ангилсан мэдээллийг тогтолцоог салбарын хэмжээнд бий болго	Салбарын ажилтан, албан хаагчдын хүйсээр ангилсан мэдээллийг тогтолцоог салбарын хэмжээнд бий болго
2.2.	Хүйсээр ангилсан мэдээллийг бурдучуулж, нэгтгэх, тайлгах тогтолцоог салбарын хэмжээнд бий болго	Хүйсээр ангилсан мэдээллийг бурдучуулж, нэгтгэх, тайлгах тогтолцоог салбарын хэмжээнд бий болго	Хүйсээр ангилсан мэдээллийг бурдучуулж, нэгтгэх, тайлгах тогтолцоог салбарын хэмжээнд бий болго	Хүйсээр ангилсан мэдээллийг бурдучуулж, нэгтгэх, тайлгах тогтолцоог салбарын хэмжээнд бий болго	Хүйсээр ангилсан мэдээллийг бурдучуулж, нэгтгэх, тайлгах тогтолцоог салбарын хэмжээнд бий болго	Хүйсээр ангилсан мэдээллийг бурдучуулж, нэгтгэх, тайлгах тогтолцоог салбарын хэмжээнд бий болго
2.3.	Салбарын хэмжээнд ялгаварлан гадуурхалт, хөндэрт сууринласан аливаа хүчирхийлээс антид ажлын орчин бий болго, сайн туршлагыг нэвтрүүлэх	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд ялгаварлан гадуурхах, ажлын дарамтын байрны бэлгийн дарамтын талаарх гомдол хулээн авах, шийдвэрлэх” талаар тусгах	Дотоод журамд тусгасан байгууллагын тоо	Хүйсээр ялгаварлан гадуурхах, ажлын байрны дарамт “Хүйсээр ялгаварлан гадуурхах, ажлын дарамтын байрны бэлгийн дарамтын асуудлыг байгууллагын ёс зүйн зөвлөлийн дурэмд тусгах	Салбарын ажилтан, албан хаагчдын хүйсээр ангилсан мэдээллийг тогтолцоог салбарын хэмжээнд бий болго	Салбарын ажилтан, албан хаагчдын хүйсээр ангилсан мэдээллийг тогтолцоог салбарын хэмжээнд бий болго
2.4.	Ажлын байран дахь нас, хүйсийн ялгаварлан гадуурхалт болон ажлын байрны бэлгийн дарамтын талаарх мэдлэг олгох сургалтыг салбарын хэмжээнд зохион байгуулах	Зохион байгуулсан сургалтын тоо	Хүйсээр ялгаварлан гадуурхах, ажлын байрны дарамт “Хүйсээр ялгаварлан гадуурхах, ажлын дарамтын байрны бэлгийн дарамтын талаарх мэдлэг олгох сургалтыг салбарын хэмжээнд зохион байгуулах	Хүйсээр ялгаварлан гадуурхах, ажлын байрны дарамт “Хүйсээр ялгаварлан гадуурхах, ажлын дарамтын байрны бэлгийн дарамтын талаарх мэдлэг олгох сургалтыг салбарын хэмжээнд зохион байгуулах	Хүйсээр ялгаварлан гадуурхах, ажлын байрны дарамт “Хүйсээр ялгаварлан гадуурхах, ажлын дарамтын байрны бэлгийн дарамтын талаарх мэдлэг олгох сургалтыг салбарын хэмжээнд зохион байгуулах	Хүйсээр ялгаварлан гадуурхах, ажлын байрны дарамт “Хүйсээр ялгаварлан гадуурхах, ажлын дарамтын байрны бэлгийн дарамтын талаарх мэдлэг олгох сургалтыг салбарын хэмжээнд зохион байгуулах
2.5.	Албан жандэрийн талаарх ойлготт мэдлэгийг дээшлүүлэх, жандэрийн эрх тэш байдлыг	Сайн туршлагыг сургалчилсан Байх	Албан жандэрийн талаарх ойлготт мэдлэгийг дээшлүүлэх, жандэрийн эрх тэш байдлыг	Албан жандэрийн талаарх ойлготт мэдлэгийг дээшлүүлэх, жандэрийн эрх тэш байдлыг	Албан жандэрийн талаарх ойлготт мэдлэгийг дээшлүүлэх, жандэрийн эрх тэш байдлыг	Албан жандэрийн талаарх ойлготт мэдлэгийг дээшлүүлэх, жандэрийн эрх тэш байдлыг

2.6.	хангах чиглэлээр хэрэгжүүлж байгаа сайн туришлага, ажиллагааг сурталчлах	Чиглэлээр хангах хэрэгжүүлж байгаа сайн туришлага, ажиллагааг сурталчлах	Хамтын ажиллагааг хөгжүүлсэн байх	Жөндэрийн асуудлаар төр-иргэний нийгэм-хувийн хэвшил-олон улсын түншлэгчдийн олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх
2.7.	Ажилд авах, ажлаас халахад нас, хүйсээр ялгаварлан гадуурхах байдлыг бууруулах	Ажил олгогчдод чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Ажлын байранц хүйсээр ялгаварлан гадуурхах, ажлын байрны дарамт, бэлтгийн дарамтанд өргөхөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл сургалчилгааны ажлыг салбарын хэмжээнд өрнүүлэх
2.8.	Салбарын хэмжээнд ажлын байрны хөдөлмөрийн Нехцэлийн үнэлгээг хийж, зөвлөмж гарган хэрэгжилтийг хангах	Үнэлгээ зөвлөмж байх	Хийгдэж хүргүүлсэн хангадсан байх	Зөвлөмжийн хэрэгжилт боловсронтуй болгох
2.9.	Ажлын байрны аливаа дарамт, нас, хүйсээр ялгаварлан гадуурхалт байгаа эсэхийг асуултын аргаар судалгаа хийх	Судалгаа хийгдсэн байх	Ажлын байрны стандартыг боловсронтуй болгох	Ажлын байрны стандарт шинэчлэгдсэн байх

Зорилт 3. Салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээнд жөндэрийн мэдрэмжтэй болгох арга зүйт нэвтрүүлэх

<p>Хүрэх үр дүн: Салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээнд жөндэрийн мэдрэмжтэй болж, эрэгтэй эмэгтэй хумуусийн нийгмийн оролцоог тэгш хангах орчин бурдэнэ.</p> <p>Зам, тээврийн салбарт жөндэрийн тэгш байдлыг хангах тогтолцоог бурдгүүлэх</p>	<p>Жендерийн эрх байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийж зөвлөмжийг хэрэгжүүлсэн байдалд үнэлгээ хийх үнэлгээ, судалгааг хийх</p>	<p>Жендерийн эрх байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийж зөвлөмжийг хэрэгжүүлсэн байдалд үнэлгээ хийх үнэлгээний тайлан</p>
<p>3.2. Салбарын байгууллага, нэгж бүрт жөндэрийн тэгш байдлыг хангах</p>	<p>Салбарын байгууллага, нэгж бүрт жөндэрийн тэгш байдлыг хангах үйл төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж тайлганах удирдамж болговсруулсан хүргүүлэх</p>	<p>Удирдамж хүргүүлсэн байх</p>
<p>3.3.</p>	<p>Харьяа байгууллагуд ашиглахад зориулсан ажлын орчин нөхцөлийн жөндэрийн мэдрэмжийг үзэлэх шалтуур үзүүлэлтийг тодорхойлох</p>	<p>Шалтуур үзүүлэлтийг тодорхойлсон байх</p>
<p>3.4.</p>	<p>Салбарын байгууллагуудаас хийж буй судалгаа, үнэлгээ, хэрэглэгчээс авах судалгаанд</p>	<p>Удирдамж боловсруулсан байх</p>

3.5.	Хүйсийн оруулах, тайландаа ангиж дун хийгилээ хийх удирдамж гаргах	Узүүлэлтийг ур дунг хүйсээр шижилгээ	Эмэгтэй, эрэгтэй ажиллагчад зохиостой хөдөлмөрийн орчин нөхцөлийг бүрдүүлсэн байх" тэсэн узүүлэлт оруулах
3.6.	Зам, салбарын судалгааг мэдрэмжтэй болгох	Тээврийн хэрэглэгчийн жендерийн байх	Судалгааг нас, хүйсээр ангилсан Салбарын жендерийн бодлогын хэрэгжилтэд оролцоонд сууринсан жендерийн үнэлгээ хийж, жендерийн талаар баримтлах цаашдын чиглэлийг тодорхойлох
3.7.	Салбарын эрэгтэйчүүдийн мэндийн мэдлэг, өөрчлөх сургаль сургачилгааны зожион байгуулах	Хэмээнд эрүүл талаарх хандлагыг сургалт ажлыг	Тодорхой арга хэмжээ зожион байгуулсан байх
	Эрүүл зожион замаар эрүүл урьдчилтан үзлэгт хамруулах байгуулгын журам"-д тусгах	Хөдөлмөрийн дотоод журамд холбогдох заалт тусгасан байх	



Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны
12 дугаар сарын 27-ны өдрийн 12 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРТ ЖЕНДЭРИЙН

ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

(2021-2026)

Нэр томъёоны товч тайлбар

- Ажил ар гэрийн амьдралын тэнцвэр:** Эмэгтэй, эрэгтэй ажилчдын гэр бүлийн үүрэг хариуцлагыг анхаарч тооцоогүй бодлого төлөвлөлт нь эмэгтэйчүүдийг ажлын байрандаа ахиж дэвшихэд садаа болж, цалин хөлс багатай, баталгаагүй ажил уруу түлхдэг ба харин эрэгтэйчүүдийг гэр бүлийнхээ амьдралд оролцох боломж, чадварыг нь хязгаарлан эрүүл мэндийн эрсдэлийг нь ихэсгэдэг. Тиймээс хөдөлмөр эрхлэлт болон гэр бүлийн үүрэг хариуцлагыг зохистойгоор хослуулж ажил ар гэрийн тэнцвэрийг хангах нь жендэрийн тэгш байдлыг хангах үйл явцын нэгэн хэсэг болно.
- Жендэрийн дүн шинжилгээ:** Бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, нийгмийн янз бүрийн бүлгийн эрэгтэй эмэгтэй, хүмүүсийн хэрэгцээнд сууриссан эсэхийг, мөн оролцох болон үр ашиг хүртэх тэгш боломжийг тэдэнд бий болгож байгаа эсэхийг үнэлэн судалж, анхаарч тооцох үйл явц юм. Үүнд зөвхөн хүйсээр ангилсан мэдээлэл бус, бодлогын дүн шинжилгээ, чанарын судалгааны аргуудыг хослуулан ашигладаг.
- Жендэрийн мэдрэмж:** Эмэгтэй, эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээг, мөн тэдний хөгжлийн үйл явцад оролцох болон үр шимиийг нь хүртэхэд хязгаарлалт болж буй хүчин зүйлсийг анхаарч тооцох хүсэлт эрмэлзэл, мэдлэг чадварыг тодорхойлсон ойлголт.
- Жендэрийн статистик:** Хүйсээр ангилсан мэдээллийг цуглуулах, нэгтгэх, шинжлэх, бодлого төлөвлөлтөд ашиглах замаар жендэрийн тулгамдсан асуудлыг илүү тодорхой ойлгох, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлсийг тооцох арга хэрэгсэл.
- Жендэрийн эрх тэгш байдал:** Эмэгтэй эрэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш

хувь хэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас анgid байхыг хэлнэ.

6. **Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд нэгтгэх:** Бүх хүрээ, төвшний аливаа бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, түүний дотор хууль тогтоомж, төсөл хөтөлбөрийн эмэгтэй, эрэгтэй хүмүүст, нийгмийн бүлгүүдэд ялгаатай нөлөөлөх байдлыг анхаарч тооцох, тэдний ялгаатай хэрэгцээ болон мэдлэг туршлагыг эн тэнцүү үнэлж, анхаарах үйл явц, стратеги.
7. **Жендэрийн хэвшмэл ойлголт:** Эмэгтэй эрэгтэй хүмүүсийн тодорхой бүлгүүдийн гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурийн талаарх хялбаршуулсан өрөнхий ойлголт бөгөөд тэдний ялгаатай хэрэгцээг бодлого төлөвлөлтөд анхаарч тусгахад садаа болж, шударга бус хандахын, аливаа шударга бус байдлыг зөвтгөх үндэс болж байдаг.
8. **Жендэрийн шалгуур үзүүлэлт:** Жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого төлөвлөлтөд, үйл ажиллагааны үр дүнг үнэлэх тоон болон чанарын үзүүлэлтүүд. Ийм үзүүлэлтүүд нь мөн жендэрийн тэгш байдлын агуулга, мөн чанарын талаар мэдээлэл өгдөг.
9. **Хүйсээр ангилсан мэдээлэл:** Статистикийн нэгэн үзүүлэлт болох хүйсээр ангилсан тоон мэдээлэл нь охид, хөвгүүд, эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн бодит нөхцөл байдлыг харьцуулан үзэх, жендэрийн зөрүү, тэгш бус байдлыг илрүүлэн залруулах боломж олгохоос гадна бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмж болон салбарын үйл ажиллагаан дахь эмэгтэй эрэгтэйчүүдийн оролцооны дүр зургийг гаргахад хүйсээр ангилсан мэдээлэл тусална.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Зам, тээврийн салбарт баримтлах жендэрийн бодлого (Цаашид “Салбарын жендэрийн бодлого” гэх) нь тус салбарт хэрэгжүүлэх жендэрийн үйл ажиллагааны хүрээ, чиг хандлагыг тодорхойлсон дунд хугацааны баримт бичиг юм.

Салбарын жендэрийн бодлого нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, Засгийн газрын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр /2017-2021/ болон Зам, тээврийн салбарын бодлого төлөвлөлт, үйл ажиллагаатай уялдан хэрэгжинэ.

Оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээгээр салбарын хэмжээний жендэрийн бодлого төлөвлөлтийг хийх, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, ажил үйлчилгээ бүтээгдэхүүнд ашиглах хэрэгцээ шаардлага байгааг тодорхойлсон.

Зам, тээврийн салбарын хүний нөөцийн бодлогын төлөвлөлтийг жендэрийн мэдрэмжтэй хийх, хэрэгжүүлэхэд өнөөгийн статистик мэдээллийн байдал хангалтгүй байна. Хувийн хэвшилд ажиллагсдын хүйсээр ангилсан мэдээллийг гаргаж ашиглаж чадахгүй байгаа нь нийт ажиллагсдын ажлын орчин нөхцөлийг бодитой үнэлэх боломжгүй байна.

Хүйсээр ангилсан мэдээллийг эмэгтэй эрэгтэйчүүдийн тоо төдий байдлаар бус, цалин хөлс, эрүүл мэнд, нийгмийн даатгалд, мэргэжлийн болон хувь хүний хөгжлийн сургалтад хамрагдалт, шагналт урамшуулал, ажлын цагийн ачаалал, илүү цагаар ажилласан байдал зэрэг олон үзүүлэлтээр цуглуулж, нэгтгэх шаардлагатай байна. Хүйсээр ангилсан мэдээлэлд мөн тухайн салбарт ажиллаж буй гадаадын ажиллах хүчийг ч хамруулах шаардлага ч үүсч байна.

Зам, тээврийн салбарын бодлого төлөвлөлтийг “хүн” төвтэй, жендэрийн мэдрэмжтэй болгохын тулд эн тэргүүнд хүйсээр ангилсан тоон мэдээлэл, үзүүлэлтийг тогтмол, бүрэн цуглуулах, нэгтгэх, ашиглах, жендэрийн мэдрэмжтэй судалгаа шинжилгээг хөгжүүлэх, төр, хувийн хэвшлийн байгууллагуудад байгаа сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх хэрэгцээ тулгарч байна.

Энэхүү зам, тээврийн салбарын жендэрийн бодлого нь Монгол Улсын Үндсэн хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр /2017-2021/, Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 99 дугаар захирамжийн 1 дүгээр заалтаар батлагдсан “Эрэгтэй, эмэгтэй, хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /2020-2022/”-ний хэрэгжилтийг хангах төдийгүй салбарын хүний нөөц, бүтээгдэхүүн үйлчилгээнд чухал хувь нэмэр оруулах болно. Имид жендэрийн асуудлаар ажиллах мэдлэг, чадварыг салбарын хэмжээнд бүрдүүлэхийн хамтаар салбарын бүхий л бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд ашиглах, ялангуяа ашиглах, ялангуяа хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит

хийх үндсэн чиг үүрэгт жендэрийн асуудлыг тусгайлан оруулах, жендэрийн шалгуур үзүүлэлтийг боловсруулах шаардлагатай байна.

Зам, тээврийн салбарын жендэрийн мэдрэмжтэй

бодлого, төлөвлөлтийн хүрээ

Салбарын бодлого – Төлөвлөлт-Хэрэгжилт – Хяналт үнэлгээ- Судалгаа сургамж

Жендерийн тэгш байдлыг хангахад чиглэсэн салбарын бодлого нь салбарын өмнө тулгамдаж буй зорилт, төлөвлөсөн үйл ажиллагааг илүү оновчтой, үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ зам, тээврийн салбарын бодлого төлөвлөлт, үйл ажиллагааг жендерийн мэдрэмжтэй болгох, учирч буй саад бэрхшээл, хүндрэлийг арилгах, жендерийн ялгаварлан гадуурхалт, жендерт суурисан аливаа хүчирхийллээс ангид ажлын орчин бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

ХОЁР. БОДЛОГЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН

2.1. Энэхүү бодлогын баримт бичгийн зорилго нь Зам, тээврийн салбарын бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээнд жендерийн агуулгыг тусгах, жендерийн талаарх мэдлэг ойлголт, хандлагыг өөрчлөх, салбарын үр шимиийг эрэгтэй эмэгтэй хүмүүст тэгш хүртээх, гэр бүлд ээлтэй хөдөлмөрийн харилцааны орчин нөхцөлийг бүрдүүлэх, бүх хүрээнд хамтын ажиллагаа түншлэлийг хөгжүүлэх замаар жендерийн эрх тэгш байдлыг хангах, жендерийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд оршино.

2.2. Салбарын жендерийн бодлогын зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

Зорилт 1. Зам, тээврийн салбарын хэмжээнд жендерийн тэгш байдлын талаарх мэдлэг, ойлголтыг бүх түвшинд нэмэгдүүлж, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлэх

Хүрэх үр дүн: Зам, тээврийн салбарт бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээг жендерийн мэдрэмжтэй хийх чадавхи болон Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Зорилт 2. Салбарын хэмжээнд хүйсээр ангилсан статистик мэдээллийг бүрдүүлэх, ашиглах чадавхыг дээшлүүлэх, жендерийн ялгаварлан гадуурхалт, жендерт суурисан аливаа хүчирхийллээс ангид ажлын орчинг бий болгох

Хүрэх үр дүн: Хүйсээр ангилсан мэдээллийн нэгдсэн санг хүний нөөцийн бодлого төлөвлөлтөнд ашиглах, эрэгтэй, эмэгтэй ажилчдад тэгш боломж бүрдүүлэхүйц байгууллагын соёл, ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх механизм төлөвшиж, ажил-ар гэрийн амьдралын тэнцвэрт байдлыг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй ажлын орчин бүрдэнэ.

Зорилт 3. Салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээнд жендэрийн мэдрэмжтэй болгох арга зүйг нэвтрүүлэх

Хүрэх үр дүн: Салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ жендэрийн мэдрэмжтэй болж, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн нийгмийн оролцоог тэгш хангах орчин бүрдэнэ.

ГУРАВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Зорилт 1-ийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.1.1. Зам, тээврийн салбарын хэмжээнд жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг, ойлголтыг бүх түвшинд нэмэгдүүлэх;

3.1.2. Жендэрийн асуудлаар сургалт зохион байгуулах салбарын мэргэшсэн сургач багш нарыг бэлтгэх;

3.1.3. Зам, тээврийн салбарын хэмжээнд жендэрийн бодлогыг танилцуулах мэдээлэл сургалт зохион байгуулах;

3.1.4. Жендэрийн хэвшмэл ойлголт, тэгш байдлыг хангах, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх сургалтад жендэр, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтний хамруулах;

3.2. Зорилт 2-ын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.2.1. Салбарын хэмжээнд хүйсээр ангилсан мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, хүний нөөцийн бодлого төлөвлөлтөнд ашиглах;

3.2.2. Салбарын хэмжээнд ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан аливаа хүчирхийллээс ангид ажлын орчин бий болгох, сайн туршлагыг нэвтрүүлэх;

3.2.3. Салбарын эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамруулах ажлыг зохион байгуулах;

3.3. Зорилт 3-ын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.3.1. Зам, тээврийн салбарт жендерийн тэгш байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх;

3.1.2. Зам, тээврийн салбарын бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаанд жендерийн дүн шинжилгээ хийх чадавхийг бүрдүүлэх;

3.1.3. Зам, тээврийн салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээнд ашиглах жендерийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх;

ДӨРӨВ. БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

4.1. Бодлогыг 2021-2026 онд хоёр үе шаттайгаар хэрэгжинэ.

4.1.1. Эхний үе шат буюу 2021-2023 он: Энэ үе шат нь Засгийн газраас 2017-2021 онд хэрэгжүүлэх “Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”, Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 99 дугаар захирамжийн 1 дүгээр заалтаар батлагдсан “Эрэгтэй, эмэгтэй, хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /2020-2022/-ний хэрэгжилттэй уялдана.

4.1.2. Хоёрдахь үе шат буюу 2024-2026: Энэ үе шат нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын хэрэгжилттэй уялдана.

ТАВ. БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨВ, ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР

5.1. Бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг дараах эх үүсвэрээр бүрдүүлнэ.

- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө
- Хандивлагч улс, олон улсын байгууллагын тусlamжийн хөрөнгө
- Хувийн хэвшлийн хандив, тусlamжийн хөрөнгө
- Бусад

5.2. Бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр нарийвчлан гаргаж, хэрэгжүүлэгч болон оролцогч талуудыг тодорхойлж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

**ЗУРГАА. БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН УДИРДЛАГА,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

6.1. Бодлогын хэрэгжилтийг Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дахь Жендерийн орон тооны бус салбар зөвлөл удирдан зохион байгуулна.

6.2. Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь бодлогын хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Хяналт-шинжилгээний үр дүнг Жендерийн салбар зөвлөл хэлэлцэн, салбарын холбогдох бодлого, төлөвлөлт, төсөвлөлт, үйл ажиллагаанд тусгана.

6.3. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн дагуу бодлогын хэрэгжилтийн тайланг Жендерийн үндэсний хороонд дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор хүргүүлнэ.

6.4. Бодлогын эхний үе шатны хэрэгжилтийн үр дүнг 2022 оны эхний улиралд багтаан үнэлж, хоёрдугаар шатанд авах арга хэмжээний талаар дүгнэлт, зөвлөмж гаргана.

--оOо—